

## II-үлрал Монголын симфони бүлэг сэдвийн шалгалт

1. Амьдралын утга учир, хүний сэтгэлийн ертөнцийг гүн гүнзгий илэрхийлж чаддаг дан хөгжмийн том хэлбэрийн бүтээл болох анхны симфонийг 1759 онд бичсэн, симфонийг үндэслэн хөгжмийн урлагийн түүхэнд “Симфонийн эцэг” хэмээн мөнхөрсөн Австрийн хөгжмийн зохиолчийг сонгоорой.

- A. И.Гайдн
- B. А.Моцарт
- C. Ф.Шуберт
- D. Л.Бетховен

2. Эртний грек хэлний нийцэл, дуурьсал гэсэн утгатай үг. Байгаль, нийгэм, хүний сэтгэхүйн ертөнцийг илэрхийлэх хөгжмийн урлагийн том төрлийг юу гэж нэрлэдэг вэ? Зөв хариултыг сонгоорой.

- A. Кино
- B. Дуурь
- C. Симфони
- D. Бүжгэн жүжиг

3. Монголын хөгжмийн урлагт гарсан томоохон ололт болох симфонийн анхдагч хэмээгддэг, энэ симфонидоо эрх чөлөө, жаргалант амьдралаа тэмцэн олсон ард түмэн, монгол орны эрт, эдүгээ, ирээдүйг тусган харуулжээ. Энд хэний, ямар бүтээлийн тухай өгүүлж байна вэ?

- A. Л.Мөрдорж “Миний эх орон”
- B. Б.Шарав “Хоёрдугаар симфони”
- C. Ц.Нацагдорж “Өргөөний баяр наадам”
- D. Ц.Намсрайжав “Хувьсгалт баатарлаг марш”

4. Хөгжмийг сонсоод бүтээлийн зохиолч болон нэрийг сонгоорой.

- A. А.Моцарт "40-р симфони"
- B. М.Глинка "Арагоны хота"
- C. Л.Бетховен "5-р симфони"
- D. И.Гайдн "94-р симфони"

5. Монголд симфони хөгжмийн анхны гараа хэзээ эхэлсэн бэ?

- A. 1955 он, Л.Мөрдорж "Миний эх орон"
- B. 1950 он, Ц.Намсрайжав "Хувьсгалт баатарлаг марш"
- C. 1954 он, Э.Чойдог "Монголын сайхан орон"
- D. 1994 он, Ц.Нацагдорж "Өргөөний баяр наадам"

6. Монголын анхны бүрэн хэмжээний симфони ямар нэртэй вэ?

- A. Л.Мөрдорж "Миний эх орон"
- B. Ц.Намсрайжав "Хувьсгалт баатарлаг марш"
- C. Э.Чойдог "Монголын сайхан орон"
- D. Ц.Нацагдорж "Өргөөний баяр наадам"

7. Ц.Намсрайжав "Хувьсгалт баатарлаг марш" симфони удиртгалд гол сэдэв болгон ашигласан хувьсгалын дуунуудыг сонгоорой. (3 хариулт сонгоно уу)

- A. "Шивээ Хиагт"
- B. "Монголын самолёт"
- C. "Улаан туг"
- D. "Магнаг үсэгтэй туг"
- E. "Ангир шар"

8. Л.Мөрдорж “Миний эх орон” симфонийн тухай мэдээлэлд тохирох хэсгүүдийг сонгоорой. (2 хариулт сонгоно уу)

- A. Хөгжмийн зохиолч энэ симфонидоо эрх чөлөө, жаргалант амьдралаа тэмцэн олсон Монгол орны эрт, эдүгээ, ирээдүйг хөгжмийн хэлээр дүрсэлжээ.
- B. Энэ симфони нь уламжлалт 4 ангитай, анги болгоны хурд, хүч, хөгжүүлэг, хэлбэр нь сонгодог симфонийн зүй тогтлоор бүтээгдсэн.
- C. Монгол ардын дуу “Гоолингоо” “Цомбон туурайтай хүрэн” болон хувьсгалын дуу болох “Магнаг үсэгтэй туг” “Агаараар нисдэг Аэроплан” зэрэг дуунуудыг симфонийнхоо гол сэдэв аялгуу болгон хөгжүүлсэн.
- D. Хөгжмийн зохиолч зохиолдоо хувьсгалын дуунуудаас “Шивээ Хиагт” “Монголын самолёт” “Магнаг үсэгтэй туг” “Ангир шар” гэсэн гурван дууг сонгон авч гол сэдэв аялгуу болгон ашигласан байдаг.
- E. Энэ симфони нь гуулин үлээврийн сүрлэг дуугаралттай уриа дуудлагын хөгжмөөр эхэлнэ. Хөгжмийн зохиолч морин хуурын татлага, бий биелгээ, хүүхдийн гийнгоо, уртын дууны шинжтэй ая аялгуу, уухайн маягтай түрлэг зэргээр бүтээлийнхээ утга санааг тод томруун дүрслэн илэрхийлжээ.

9. Энд ямар бүтээлийн тухай өгүүлсэн байна вэ?

“Энэ симфони нь 4 ангитай. Хөгжмийн зохиолч бүтээлдээ шашны хүрал номын ая дан, үнзад ламын уншлага, хөөмий, цуурын аргил хоолойн хүнгэнэлт, цамын бүжгийн хэмнэл, бөөгийн дуудлага, уртын дууны ая аялгууны онцлогийг тусган бичжээ”

- A. Б.Шарав “II симфони”
- B. Л.Мөрдорж “Миний эх орон”
- C. Э.Чойдог “Монголын сайхан орон”
- D. Ц.Нацагдорж “Өргөөний баяр наадам”

10. Б.Шарав “Хоёрдугаар симфони” бүтээлийн онцлогт тохирох утгыг сонгоорой.

(5 хариулт сонгоно уу)

- A. Найрал дуутай
- B. Литаврын гоцлолтой
- C. Уртын дууны ая аялга шингэсэн
- D. Бөөгийн дуудлагын ая аялга сонсогдоно
- E. Морин хуурын татлага, бий биелгээний шинж төрхтэй хөг аялгуу
- F. Буддын шашны хурал, номын ая данг санагдуулам хахир ширүүн дуугаралт
- G. Монгол ардын дуу “Гоолингоо” дууны аялгууг гол сэдэв болгон хөгжүүлсэн

11. Ц.Нацагдоржийн “Өргөөний баяр наадам” бүтээл нь симфонийн ямар төрлөөр бичигдсэн бэ?

- A. Симфони зураглал
- B. Симфони удиртгал
- C. Симфони уран сэтгэмж
- D. Симфони чуулбар

12. Ц.Нацагдоржийн “Өргөөний баяр наадам” симфони удиртгалын хэсгээс сонсоод тухайн хэсгийн утга агуулгад тохирох зургийг сонгоорой.



A. Хурдан морины уралдаан



B. Бөхийн барилдаан



C. Сурын харваа

13. Ц.Нацагдоржийн “Өргөөний баяр наадам” симфони удиртгалын хэсгээс сонсоорой. Сонссон хэсэгт ямар хөгжмийн зэмсгүүд голлох үүргийг гүйцэтгэж байна вэ? (2 хариулт сонгоно уу)

- A. Чавхдаст
- B. Модон үлээвэр
- C. Гуулин үлээвэр
- D. Цохивор

